



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/203

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн З.Дашдолгор (ГВ85012502)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 7 дугаар гудамж 713 тоотод байршилтай 6308005371 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 649 м2 газрын газар эзэмших эрхийг Ц.Ариунжаргал (ГМ69102809)-д, Ш.Жавхлант (ГЮ75020113)-ын Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 1 дүгээр гудамж Г18 тоотод байршилтай 6308007677 нэгж талбар бүхий автомашины гараашны зориулалтаар эзэмшиж буй 36 м2 газрын газар эзэмших эрхийг О.Дүүрэнжаргал (ГЮ98051125)-д, Д.Алтангэрэл (ГР90040411)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар гудамж 1617 тоотод байршилтай 6308007440 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 605 м2 газрын газар эзэмших эрхийг Г.Өлзий (ГР89120418)-д, Б.Нямсүрэн (ГА95111206)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 5 дугаар гудамж 514 тоотод байршилтай 6308004189 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 702 м2 газрын газар эзэмших эрхийг Л.Амартүвшин (МУ95032716)-д тус тус шилжүүлсүгэй.

2. Ц.Ариунжаргал, О.Дүүрэнжаргал, Г.Өлзий, Л.Амартүвшин нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/323 дугаар захирамжийн З.Дашдолгор, 2016 оны А/364 дүгээр захирамжийн Ш.Жавхлант, 2018 оны А/541 дүгээр захирамжийн Д.Алтангэрэл, 2021 оны А/189 дүгээр захирамжийн Б.Нямсүрэн нартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010182